



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Ухаалаг төр рүү шилжих талаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгыг тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дэмжин эрчимжүүлэх чиглэлээр тодорхой бодлого, арга хэмжээний төсөл боловсруулж, Байнгын хорооны 2014 оны жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

С.Дэмбэрэл -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

А.Бакей -Улсын Их Хурлын гишүүн
М.Батчимэг -Улсын Их Хурлын гишүүн
Су.Батболд -Улсын Их Хурлын гишүүн
Д.Батцогт -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Батзандан -Улсын Их Хурлын гишүүн
Р.Бурмаа -Улсын Их Хурлын гишүүн
Б.Наранхүү -Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллах дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Б.Цогоо -Төрийн албаны зөвлөлийн дарга
С.Цэдэндамба -Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга

Ц.Норовдондог -Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга

Н.Энхтуяа -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын захирал


М.Тайшир -Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

С.Энхцэцэг

-Төрийн байгуулалтын байнгын хорооны
ажлын албаны референт

2.Ажлын хэсгийн үйл ажиллагаанд судлаачид, мэргэжлийн холбоод, иргэдийн төлөөллийг тухай бүр татан оролцуулж, хийсэн ажлын үр дүнгийн талаар Байнгын хорооны хуралдаанд 2014 оны нэгдүгээр улиралд багтаан тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч /С.Дэмбэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ